

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2023.05.04

Тендер шалгаруулалтын нэр: **Хаягдал утааны хэмжилтийн тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл худалдан авах**

Тендер шалгаруулалтын дугаар: НАОБТГ-23/05

Нийслэлийн Агаар орчны бохирдолтой тэмцэх газар нь тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан этгээдийг **Хаягдал утааны хэмжилтийн тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл худалдан авах** ажлыг гүйцэтгэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Сонирхогч этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендерийн баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд тендерийн баримт бичгийн үнийг төлснөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй болно.

Тендер нь түүнийг нээснээс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй.

Тендерийн баталгаа: Шаардахгүй

Тендерийг 2023 оны 05 дугаар сарын 22-ны 11 цаг 00 минутаас өмнө тендерийн баримт бичигт заасан хэлбэрээр ирүүлэх ба тендерийн нээлтийг 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн, 11 цаг 30 минутад зохион байгуулна.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: “Эрхгүй”

Урьдчилсан худалдан авах ажиллагааны урилга эсэх: “Үгүй”

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг доорх хаягаар хүргүүлж болно.

Хан-Уул дүүрэг, Наадамчдын гудамж, Арцатын ам Нийслэлийн Засаг захиргааны шинэ Хангарьди ордон. Баруун жигүүр 1 дүгээр давхар, 02 тоот өрөө. Утас: 11314876